



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/149

Мандалговь

Ахмадын Улсын аварга шалгаруулах Шатрын
тэмцээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.4.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч Ж.Лхагвагийн нэрэмжит Ахмадын Улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнд дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэгт шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 1,600,000 (Нэг сая зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100358

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын
06-ны өдрийн 4 дугаар захирамжийн хавсралт



АХМАДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭНД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын утга	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Тэргүүн байрын мөнгөн шагнал /Эрэгтэй ангилал/	2	500,000	1,000,000
2	Тэргүүн байрын мөнгөн шагнал /Эмэгтэй ангилал/	2	300,000	600,000
	НИЙТ ДҮН			1,600,000